



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/411

Алтай хот

**Дэд зөвлөлийг шинэчлэн байгуулах  
тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа компаниуд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн эвслийн санал, санаачилгыг дэмжин ажиллаж, тайланг жил бүр гарган, иргэд олон нийтэд мэдээлж ажиллахыг дэд зөвлөл (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.


3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2013 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/172 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ф.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20 21 оны  
09 дугаар сарын 09-ны өдрийн 1411 дугаар  
захирамжийн хавсралт



## ДЭД ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Дэд зөвлөлийн дарга: -(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

- (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)
- (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- (Хууль, эрх зүйн хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа, Хууль тогтоомжийн системчлэл, хүний эрхийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- (“Алтайн бичил уурхайчдын эв нэгдлийн холбоо” ТББ-ын зохицуулагч)
- (Иргэн Б.Сүхбаатар)

Нарийн бичгийн дарга:-(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн уул уурхай, байгаль орчин, аялал хариуцсан мэргэжилтэн)

\_\_оОо\_\_